



“Инвескор ББСБ” ХК
2022 оны 3 дугаар улирал

Үйл ажиллагааны тайлан /НЭГТГЭСЭН/

7709 - 0077
info@invescore.mn
www.invescore.mn

Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Покет - Дижитал зээл	6. ЖДҮ дэмжих хөтөлбөр
7. Олон Улсын зах зээл	8. MFR рейтинг	9. Инвескор платинум карт	10. НҮБ-ын хөтөлбөр	11. Санхүүгийн үр дүн	12. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	13. Хувьцааны ханш

Агуулга

1. Гол амжилтууд	03
2. Компанийн бүтэц	04
3. Зээлийн үйл ажиллагаа	05
4. Борлуулалтын суваг	06
5. Покет - Дижитал зээл	07
6. ЖДҮ дэмжих хөтөлбөр	08
7. Олон Улсын зах зээл	09
8. MFR рейтинг	10
9. Инвескор Платинум карт	11
10. НҮБ-ын хөтөлбөр	12
11. Санхүүгийн үр дүн	13-14
12. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	15
13. Хувьцааны ханш	16

Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Покет - Дижитал зээл	6. ЖДҮ дэмжих хөтөлбөр
7. Олон Улсын зах зээл	8. MFR рейтинг	9. Инвескор платинум карт	10. НҮБ-ын хөтөлбөр	11. Санхүүгийн үр дүн	12. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	13. Хувьцааны ханш

Гол амжилтууд



Инвескор санхүүгийн байгууллага нь Катар Улсад 2022 оны 11 сард зохион байгуулагдах Хөлбөмбөгийн ДАШТ-ийн шууд дамжуулалтын Ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллахаар боллоо.

Олон улсын "MicroFinanza Rating" SRL байгууллагаас 2021 оны 9 сард авсан "A-" үнэлгээгээ 2022 оны 9 сард "A" болгон ахиулж, Монгол Улсын санхүүгийн байгууллагууд дундаа хамгийн өндөр үнэлгээ авлаа.



Монгол Улсад анх удаа хэрэгжиж буй "НҮБ-ын залуу төлөөлөгч-Байгаль орчны манлайлал" хөтөлбөрийг компанийн зүгээс дэмжин ажиллаж байна.

"Инвескор ББСБ" ХК нь Голомт банктай хамтарч, үнэнч харилцагчдадаа зориулан Инвескор платинум кредит картыг хэрэглээнд нэвтрүүлээ.





Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Покет - Дижитал зээл	6. ЖДҮ дэмжих хөтөлбөр
7. Олон Улсын зах зээл	8. MFR рейтинг	9. Инвескор платинум карт	10. НҮБ-ын хөтөлбөр	11. Санхүүгийн үр дүн	12. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	13. Хувьцааны ханш

Компанийн бүтэц




“Инвескор” санхүүгийн байгууллага нь бичил санхүүгийн зах зээлд дэвшилтэт технологи, шинэлэг шуурхай үйлчилгээг нэвтрүүлж, харилцагчдынхаа санхүүгийн “хариуцлагатай дэмжигч” байх зорилготойгоор 2016 онд байгуулагдсан.

2016



Зээлийн үйл ажиллагаа

Зээлийн багц, харилцагчийн тоо



Зээлийн багц өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 91 хувиар өсч 285 тэрбум төгрөг, харилцагчийн тоо 102 хувиар өсч 126 мянгад тус тус хүрсэн байна.

Зээлийн багц (бүтээгдэхүүнээр %)



Зээлийн багцын чанар

2021Q3



2021



2022Q3



■ Хугацаа хэтэрсэн ■ Чанаргүй

Q3 - 09.30 өдрийн байдлаар

Агуулга

1. Гол амжилтууд

2. Компанийн бүтэц

3. Зээлийн үйл ажиллагаа

4. Борлуулалтын суваг

5. Покет - Дижитал зээл

6. ЖДҮ дэмжих хөтөлбөр

7. Олон Улсын зах зээл

8. MFR рейтинг

9. Инвескор платинум карт


10. НҮБ-ын хөтөлбөр

11. Санхүүгийн үр дүн

12. Зохистой харьцааны үзүүлэлтүүд

13. Хувьцааны ханш

Борлуулалтын суваг



17 салбар

Инвескор ББСБ ХК нь Монгол Улсад нийт 17 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Байршил

Үүнээс 16 нь Улаанбаатар хотод, 1 нь Эрдэнэт хотод үйл ажиллагаа явуулж байна.

4 аймаг

Инвескор Аллианс төсөл нь Монгол улсын 4 аймаг тус бүрт гишүүн ББСБ-тай.



Киргиз Улс дахь салбар





Киргиз Улсын Бишкек хотод 2 охин компани, 4 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Покет - Дижитал зээл	6. ЖДҮ дэмжих хөтөлбөр
7. Олон Улсын зах зээл	8. MFR рейтинг	9. Инвескор платинум карт	10. НҮБ-ын хөтөлбөр	11. Санхүүгийн үр дүн	12. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	13. Хувьцааны ханш

ПОКЕТ - ДИЖИТАЛ ЗЭЭЛ

2021 онд Покет платформ нь "Цахим зээлийн төв" болж бусад санхүүгийн байгууллагуудад өөрийн технологийн шийдэл, бусад давуу талуудаа санал болгож эхэлсэн. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 4 санхүүгийн байгууллагатай хамтарч Цахим зээлийн төвөөр дамжуулан 150 мянга гаруй гэрээт харилцагчдад цахим зээл олгож байна.

Гол бүтээгдэхүүн, үйлчилгээ

			
Pocket Loan	Pocket Pay	Pocket Coupon	Pocket Zero
67 тэрбум төгрөгийн зээлийн багц, 236 мянган идэвхтэй зээл	Цахим төлбөр тооцооны 550 мянга + бүртгэлтэй хэрэглэгч	100+ нэр төрлийн купон, 80+ хамтрагч байгууллага	680+ Мерчант, 900+ Брэнд, 1200+ Салбар



Урт хугацаат зээлийн бүтээгдэхүүн

Pocket аппликейшнтэй урт хугацаанд хамт байсан, санхүүгийн сахилга баттай, үнэнч хэрэглэгчдэдээ зориулан "Урт хугацаат зээлийн бүтээгдэхүүн"-ийг нэвтрүүлээд байна.

Урт хугацаат зээлийг авахын тулд Pocket аппликейшний гэрээт хэрэглэгч Boss 1 болон түүнээс дээш зэрэглэлтэй, зээл эргэн төлөх санхүүгийн чадвартай байх шаардлагатай бөгөөд тус зэрэглэлд хүрээгүй байгаа тохиолдолд бонус оноогоо цуглуулаад зэрэглэлээ нэмэгдүүлэх боломжтой юм.


Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Покет - Дижитал зээл	6. ЖДҮ дэмжих хөтөлбөр
7. Олон Улсын зах зээл	8. MFR рейтинг	9. Инвескор платинум карт	10. НҮБ-ын хөтөлбөр	11. Санхүүгийн үр дүн	12. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	13. Хувьцааны ханш

ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

RioTinto

Ковид-19 цар тахлын дараа Монгол улсын эдийн засгийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг “Инвескор ББСБ” ХК нь “Рио Тинто Монгол” ХХК-тай хамтран хэрэгжүүлж байна.

НИЙТ ХАРИЛЦАГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



Импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгч

Эмэгтэй бизнес эрхлэгч

Хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгч

Байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч

Өрх толгойлсон эцэг/эхийн бизнес

2022 оны 3 дугаар улирлын байдлаарх үр дүн

3.1 Тэрбум

төгрөгийн зээлийн багц

152+

ААН болон иргэн

ХАМТАРСАН ХӨТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

30 Сая төгрөг

Нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ

4.8 хувь

Зээлийн жилийн хүү

540+

ажлын байр хадгалсан

0%

Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хувь

24 сар хүртэл

Зээлийн хугацаа

0.0 хувь

Зээл судалсны шимтгэл

Зээлдэгчид тавигдах шаардлага

- ✓ Үйлдвэрлэл үйлчилгээний бизнес эрхэлдэг байх;
- ✓ Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхэлдэг байх;
- ✓ 6 сар ба түүнээс дээш хугацаагаар идэвхтэй үйл ажиллагаа явуулсан байх.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

“Инвескор ББСБ” ХК нь олон улсад зах зээлээ тэлэх стратегийн хүрээнд Киргиз улсад 2 охин компани (“Invescore CA” MFC, “Pocket KG” LLC) байгуулсан бөгөөд үйл ажиллагаа нь хурдацтай тэлж, өргөжиж байна.

“INVESCORE CA” MFC

Компани нь 30 ажилтан, 4 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. 2022 оны 3 дугаар улиралд 10.8 тэрбум төгрөгийн зээл олголт хийсэн бөгөөд нийт олголтын 46 хувийг жижиг дунд бизнес эрхлэгчид эзэлж байна.

2022 оны 3 дугаар улирлын үр дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:



13.7 тэрбум ₮

Зээлийн багц 13,7 тэрбум төгрөгт хүрч 117%-иар өссөн.

16.6 тэрбум ₮

Нийт хөрөнгө 12.8 тэрбум төгрөгт хүрч 121%-иар өссөн.

1.9%

Хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь 2.7%, Чанаргүй зээлийн эзлэх хувь 1.9% байна.

50%

Нийт зээлийн тоо 987-т хүрч 50%-иар өссөн.

“POCKET KG” LLC



Компани нь Монгол улсын зах зээлд тэргүүлж буй цахим хэтэвч, дижитал зээлийн Покет платформыг Киргиз улсын зах зээлд нийцүүлэн өөрчилж, нэвтрүүлэхэд бэлэн болоод байна.

2022 оны эхний хагас жилд Киргиз улсын төв банкнаас төлбөрийн системийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлөө авсан ба аппликейшнийг нэвтрүүлэх сүүлийн тестийн ажлууд хийгдэж байна.

Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Покет - Дижитал зээл	6. ЖДҮ дэмжих хөтөлбөр
7. Олон Улсын зах зээл	8. MFR рейтинг	9. Инвескор платинум карт	10. НҮБ-ын хөтөлбөр	11. Санхүүгийн үр дүн	12. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	13. Хувьцааны ханш

MFR ОЛОН УЛСЫН РЕЙТИНГ

“Инвескор ББСБ” ХК нь олон улсын “MicroFinanza Rating” SRL байгууллагаас аваад байсан “A-” үнэлгээгээ “A” болгож ахиуллаа. Үнэлгээг тогтоосон суурь хүчин зүйлүүд нь “Инвескор ББСБ” ХК-ийн олон улсын жишигт нийцсэн компанийн засаглал, стратеги, зээлийн багцын чанар, үйл ажиллагаа, систем, санхүүгийн төлөв байдал зэрэг юм.

“A” рейтинг нь Монгол Улсын санхүүгийн байгууллагууд дундаа хамгийн өндөр үнэлгээ бөгөөд 2010 оноос хойш “Institutional Rating” үнэлгээ хийлгэсэн 500 гаруй банк санхүүгийн байгууллагуудаас ердөө 10 нь “A” үнэлгээ авч чаджээ.

Тус үнэлгээ нь “Инвескор ББСБ” ХК-ийн гадаад зах зээлээс эх үүсвэр татах болон хөрөнгө оруулагч нартай түншлэлээ идэвхжүүлэх үйл ажиллагаанд томоохон давуу тал болж байна. “MicroFinanza Rating” SRL нь банк, санхүүгийн байгууллагуудын урт хугацааны тогтвортой байдлын үнэлгээ болон зээлжих зэрэглэлийг тогтоодог дэлхийд тэргүүлэгч агентлаг бөгөөд 2000 оноос хойш дэлхийн 100 гаруй орны, 2000 гаруй санхүүгийн байгууллагуудад үнэлгээ хийжээ.



Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Покет - Дижитал зээл	6. ЖДҮ дэмжих хөтөлбөр
7. Олон Улсын зах зээл	8. MFR рейтинг	9. Платинум карт	10. НҮБ-ын хөтөлбөр	11. Санхүүгийн үр дүн	12. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	13. Хувьцааны ханш

ИНВЕСКОР ПЛАТИНУМ КАРТ



“Инвескор ББСБ” ХК нь өөрсдийн үнэнч харилцагч нартаа зориулан дэлхийн хаана ч ашиглах боломжтой олон улсын эрхтэй төгрөгийн VISA КРЕДИТ КАРТ-г хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн билээ.

2019 онд анхны кредит картаа Худалдаа Хөгжлийн Банктай хамтран гаргаж байсан бол энэ удаа Голомт банктай хамтран Инвескор Платинум кредит картыг үнэнч харилцагч нартаа санал болгож байна.

Инвескор Платинум картын давуу тал

- ✓ Минималист хэв маягийг агуулсан гоёмсог загвартай
- ✓ Дэлхийн аль ч улсад төлбөр тооцоо, гүйлгээ хийх боломжтой
- ✓ Зайнаас уншигч NFC технологийг агуулсан
- ✓ Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг EMV чип технологиор хамгаалсан
- ✓ Харилцагчийн овог, нэр зэрэг хувийн мэдээллийг картын нүүрэн талд байрлуулдаггүй

Буцаан олголттой



10%-15%-ийн буцаан олголт

Хамгийн бага хүү



2%-2.8% /сарын хүү/

Лоялти хөтөлбөрүүд нэмэгдэнэ



Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Покет - Дижитал зээл	6. ЖДҮ дэмжих хөтөлбөр
7. Олон Улсын зах зээл	8. MFR рейтинг	9. Платинум карт	10. НҮБ-ын хөтөлбөр	11. Санхүүгийн үр дүн	12. Зохиистой харьцааны үзүүлэлтүүд	13. Хувьцааны ханш

НҮБ-ын залуу төлөөлөгч-Байгаль орчны манлайлал хөтөлбөр



"Инвескор ББСБ" ХК нь Монгол Улсад анх удаа хэрэгжиж байгаа "НҮБ-ын залуу төлөөлөгч- Байгаль орчны манлайлал" хөтөлбөрийг дэмжин ажиллаж байна. 🌱
Тус хөтөлбөрийн хүрээнд байгаль орчинд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах хүсэлтэй 18-30 насны 30 залууг шалгаруулсан бөгөөд сонгогдсон оролцогчид 2 сарын турш байгаль орчны тухай мэдлэгээ тэлэн сургалтанд хамрагдаж байгаа билээ.

Түүнчлэн оролцогчид багт хуваагдан байгаль орчинд тулгарч буй асуудлуудыг шийдэх төсөл санаачлан хэрэгжүүлж эхэлсэн ба бид дараах төслүүдийг онцолж байна.



Хэмжээд Хас / Calculate and Cut

Энэхүү төсөл нь уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг таниулах, байгаль орчноо хамгаалж тогтвортой хөгжлийг цогцлоход иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой.



Гоё хүмүүстэй дэлхий

Төслийн зорилго нь 16-25 насны оюутан, сурагч залууст уур амьсгалын өөрчлөлт болон Тогтвортой Хөгжлийн Зорилтын дагуу "Хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжих" талаар мэдлэг мэдээллээр хангахад оршиж байна.



"GREENATION" Sustainable fashion

Дэлхийн нийт цэвэр усыг ихээр бохирдуулж буй хувцасны үйлдвэрлэлийн салбарт тогтвортой худалдан авалт, бүтээлч шийдлийг таниулах зорилготой төсөл юм.

Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Покет - Дижитал зээл	6. ЖДҮ дэмжих хөтөлбөр
7. Олон Улсын зах зээл	8. MFR рейтинг	9. Инвескор платинум карт	10. НУБ-ын хөтөлбөр	11. Санхүүгийн үр дүн	12. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	13. Хувьцааны ханш

САНХҮҮГИЙН ҮР ДҮН (НЭГТГЭСЭН)

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ /мянган ₮/


	2021.III	2021	2022.III
		<i>Аудитлагдсан</i>	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10,701,769	24,638,751	35,550,368
Хөрөнгө оруулалт	1,205,125	183,583	934,596
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	151,415,677	175,508,816	284,603,587
<i>Нийт зээл</i>	<i>149,542,514</i>	<i>173,192,374</i>	<i>285,178,427</i>
<i>Эрсдэлийн сан</i>	<i>3,239,185</i>	<i>3,146,865</i>	<i>7,371,309</i>
<i>Хүүний авлага</i>	<i>5,112,348</i>	<i>5,463,307</i>	<i>6,796,469</i>
Авлага	4,089,160	3,274,706	5,579,792
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	67,000	783,568	130,124
Бусад актив	2,659,829	1,980,060	7,436,048
Үндсэн ба биет бус хөрөнгө	9,221,888	5,852,811	6,093,681
Нийт хөрөнгийн дүн	179,360,448	212,222,295	340,328,198
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	44,845,232	56,477,725	80,007,308
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	21,113,454	34,396,459	80,897,656
Бонд	24,573,000	27,620,907	26,382,800
Бусад өглөг	25,146,439	18,210,441	40,319,243
Нийт өр төлбөрийн дүн	115,678,124	136,705,532	227,607,007
Хувьцаат капитал	16,282,237	16,282,237	17,193,952
Нэмж төлөгдсөн капитал	15,377,738	15,377,738	29,820,733
Хоёрдогч өглөг	-	4,972,070	5,000,000
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	32,022,348	38,884,718	60,706,506
Нийт өөрийн хөрөнгө	63,682,323	75,516,763	112,721,191
Нийт пассив ба өөрийн хөрөнгө	179,360,448	212,222,295	340,328,198

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ /мянган ₮/

	2021.III	2021	2022.III
Хүү болон түүнтэй адилтгах орлого	25,957,911	41,122,071	55,736,220
Хүү болон түүнтэй адилтгах зардал	8,593,109	12,814,237	18,557,269
Бусад хүүгийн зардал	3,128,721	5,336,908	7,394,544
Итгэлцлийн үйл ажиллагааны зардал	5,464,388	7,477,329	9,787,303
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	1,883,888	743,455	5,181,555
Хүүгийн цэвэр орлого	15,480,914	27,564,379	31,997,396
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	6,028,795	8,886,652	11,057,045
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, зардал	(110,605)	(157,173)	186,115
Нийт хүүгийн бус цэвэр орлого	5,918,190	8,729,479	11,243,160
Нийт үйл ажиллагааны орлого	21,399,104	36,293,858	43,240,556
Ажиллагсадтай холбогдолтой зардал	3,866,665	5,759,249	7,251,418
Үйл ажиллагааны бусад зардал	4,050,002	6,455,882	7,472,892
Нийт үйл ажиллагааны зардал	7,916,667	12,215,131	14,724,310
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	685,787	(368,409)	67,967
Татварын өмнөх ашиг	14,168,224	23,710,318	28,584,214
Орлогын албан татвар	2,456,626	4,518,782	5,611,256
Тайлант үеийн цэвэр ашиг	11,711,598	19,191,536	22,972,958


САНХҮҮГИЙН ҮР ДҮН (НЭГТГЭСЭН)

Нийт хөрөнгө (сая төгрөг)




Нийт хөрөнгө өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 90 хувиар өсч, 340 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Өөрийн хөрөнгө хөрөнгө (сая төгрөг)




Өөрийн хөрөнгө өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 77 хувиар өсч 112 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүү, шимтгэлийн орлого (сая төгрөг)



Хүү, шимтгэлийн орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 109 хувиар өсч 67 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Цэвэр ашиг (сая төгрөг)



Цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 97 хувиар өсч 23 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Агуулга	1. Гол амжилтууд	2. Компанийн бүтэц	3. Зээлийн үйл ажиллагаа	4. Борлуулалтын суваг	5. Покет - Дижитал зээл	6. ЖДҮ дэмжих хөтөлбөр
7. Олон Улсын зах зээл	8. MFR рейтинг	9. Инвескор платинум карт	10. НҮБ-ын хөтөлбөр	11. Санхүүгийн үр дүн	12. Зохистой харьцааны үзүүлэлтүүд	13. Хувьцааны ханш

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД (тусдаа)

Шалгуур үзүүлэлт	Байх ёстой	2021	2022.III
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	30.7%	30.4%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	33.1%	32.0%
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	31.7%	29.6%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	16.2%	17.1%
Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	30%-иас хэтрэхгүй	11.7%	9.9%
ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	70%-иас хэтрэхгүй	0.0%	0.0%
Нийт холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	25%-иас хэтрэхгүй	0.4%	4.5%
Нэг холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	10%-иас хэтрэхгүй	0.0%	4.2%
Үнэт цаасны эзэмшил / өөрийн хөрөнгө	50%-иас хэтрэхгүй	8.5%	6.3%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	+/-40%-иас хэтрэхгүй	18.0%	0.1%
Итгэлцлийн өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	74.7%	79.8%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	38.5%	25.3%
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-иас хэтрэхгүй	0.9%	0.6%

Агуулга

1. Гол амжилтууд

2. Компанийн бүтэц

3. Зээлийн үйл ажиллагаа

4. Борлуулалтын суваг

5. Покет - Дижитал зээл

6. ЖДҮ дэмжих хөтөлбөр

7. Олон Улсын зах зээл

8. MFR рейтинг

9. Инвескор платинум карт


10. НҮБ-ын хөтөлбөр

11. Санхүүгийн үр дүн

12. Зохистой харьцааны үзүүлэлтүүд

13. Хувьцааны ханш

ХУВЬЦААНЫ ХАНШ



■ Хаалтын ханш

■ Арилжааны дүн (сая төг)

Үнэт цаасны код

INV

Зах зээлийн үнэлгээ

331 тэрбум төгрөг

Гаргасан хувьцааны тоо ширхэг

75,744,281 ширхэг

Хаалтын ханш /2022.09.30/

4369 төгрөг

IPO-с хойших өсөлт

165%

Хувьцааны ханш:

4369₮

2022. Q3 жилийн өсөлт:

29%



IPO-с хойш:

165%



“Инвескор ББСБ” ХК-ийн хувьцаа нь МХБ-ийн ТОП-20 индекс болон хувьцааны бүртгэлийн I ангилалд багтдаг.